

Төгсөлтийн дараахь сургалт удирдах багшид тавигдах шаардлага

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 10 дах хэсэгт заасан дараах шаардлагыг хангасан байна.

Эмнэл зүйн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг эмнэл зүйн сургагч багш удирдана. Эмнэл зүйн сургагч багшийн сургалтад суралцах эмнэлгийн мэргэжилтэн дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэжлээрээ магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй эсхүл ахлах ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх;
2. Тухайн мэргэжлээрээ найм ба түүнээс дээш жил ажилласан байх;
3. Хүчин төгөлдөр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
4. Сургалт эрхлэх байгууллагатай гэрээ байгуулсан байх (тухайн байгууллагын үндсэн ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ, гэрээт ажилтны хувьд сургалт удирдах гэрээ байгуулах);
5. Зөвхөн нэг байгууллагад сургалт удирдах гэрээтэй байх;

Багц цагийн богино хугацааны болон эмнэл зүйн бус мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт удирдах багшид тавигдах шаардлага:

1. Тухайн мэргэжлээрээ магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй эсхүл ахлах ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх;
2. Тухайн мэргэжлээрээ найм ба түүнээс дээш жил ажилласан байх;
3. Сургалт эрхлэх байгууллагатай гэрээ байгуулсан байх (тухайн байгууллагын үндсэн ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ, гэрээт ажилтны хувьд сургалт удирдах гэрээ байгуулах);
4. Зөвхөн нэг байгууллагад сургалт удирдах гэрээтэй байх;

Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалт:

Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс улсын төсвийн санхүүжилтээр болон сургалт эрхлэх байгууллагын хүсэлтийн дагуу тухайн байгууллагын санхүүжилтээр тус тус зохион байгуулна. Сургалтыг үндэсний чиглүүлэгч багш удирдах бөгөөд сургалт 3 хоног 24 хүний бүрэлдэхүүнтэй явагдана. Сургалт нь суралцагчийн оролцоонд тулгуурласан сургалтын идэвхтэй арга бүхий жишиг хөтөлбөрийн дагуу сургалтын зорилго, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах арга зүй, үнэлгээ, үйлчлүүлэгч ба эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, багийн тусламж, үйлчилгээ болон сурган заах арга зүйн эргэх холбоо үүсгэх (Feedback), дасгалжуулах (Coaching), зөвлөгөө өгөх (Mentoring), сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (Mental care), мэргэжлийн ур чадвар олгох (Professionalism), нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх (Evidence-based medicine) арга техник зэрэг агуулгын хүрээнд явагдана.